

## 2. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын дэд бүтцийг байгуулах

### ЗОРИЛГО

Алслагдсан бүс нутаг болон шилэн кабелийн сүлжээ хүрэх боломжгүй газарт өндөр хурдны интернэт, харилцаа холбооны үйлчилгээг сансрын холбоогоор хүргэх. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төслийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн дэд бүтцийг ашиглан хэрэгжүүлнэ.

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.5.11. Сансрын технологид суурилсан гарааны шинэ компаниуд, сансрын аялал жуулчлалын симуляци хийх нээлттэй баазын судалгаа хийж, гадаад улс орнуудтай хамтран хиймэл дагуул хөөргөж, газрын станц байгуулах хөрөнгө оруулалт татах арга хэмжээг авна.

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, III үе шат (2026-2030): Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах.
- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 137 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөр.
- Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон БНФУ-ын Талес Аллейна Спейс Компани хооронд 2023 оны 10 дугаар сард байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг.

### ХҮРЭХ ҮР ДҮН

1.6  
тэрбум  
төгрөг



Хиймэл дагуулын дамжуулах багтаамжийг нэмэгдүүлэхийн тулд 4 дамжуулах буюу холбох станцуудыг Мдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн харьяа Дархан хот, Чойбалсан хот, Өлгий хот, Даланзадгад хотод байгуулна. Дээрх байршлуудыг шилэн кабель, төвийн эрчим хүчинд холбогдсон байдал, дэд бүтцийн хувьд бэлэн, нэмэлт хөрөнгө оруулалт болон бусад хүчин зүйлсийн үнэлгээ хийлгэх шаардлага гарахгүй хэмээн үзэж сонгон авсан. Дээрх станцуудад 7,3 м антенны суурийг барьж байгуулах, тоног төхөөрөмжийг суурилуулах өрөөний засварыг хийхэд зарцуулна.